

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт, тайлбарыг нэмсүгэй:

1/ 19¹ дүгээр зүйл:

“19¹ дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлд банкнаас банкнаас гаргасан хадгаламжийн сертификат арилжих:

19^{1.1}. Банк хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжаалахаар нийтэд санал болгох, эсхүл нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд гаргаж болно.

19^{1.2}. Энэ хуулийн 19^{1.1}-д заасан үнэт цаасны зах зээлд арилжаалахаар нийтэд санал болгон гаргах хадгаламжийн сертификат нь мөнгөн хадгаламжийн гэрээгээр зохицуулагдахгүй бөгөөд үнэт цаас хэлбэрээр үнэт цаасны зах зээлд арилжаалагдана.

19^{1.3}. Үнэт цаасны зах зээлд арилжаалахаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх болон банканд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоох журмыг Монгобанкны санал, шийдвэрийг харгалзан Хороо тогтооно.

19^{1.4}. Банкнаас үнэт цаасны зах зээлд гаргах хадгаламжийн сертификатын хэмжээ, нөхцөл, төрөл, төвлөрлийн үзүүлэлтэд тавигдах хязгаарлалт, хязгаарлалтыг тооцох хангах, тайлагнах, хяналт тавих журмыг холбоотой журмыг Санхүүгийн зохицуулах хорооны саналыг харгалзан Монголбанк батална.

19^{1.5}. Банк нь үнэт цаасны зах зээлд арилжаалахаар хадгаламжийн сертификат гаргахаар шийдвэрлэсэн бол Монгобанкны зөвшөөрлийг авсан байна.

19^{1.6}. Үнэт цаасны зах зээлд арилжаалахаар хадгаламжийн сертификат гаргахад энэ хуулийн 10.5.16-д заасан тайлан шаардахгүй.”

2/ 50¹ дугаар зүйл:

“50¹ дугаар зүйл.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа

50¹.1.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь тусгай программ хангамжаар дамжуулан жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон хөрөнгө оруулагчдын хооронд санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг үр ашигтайгаар зохион байгуулах зорилготой байна.

50¹.2.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны үндсэн орлого нь иргэн, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон хөрөнгө оруулагчид тусгай программ хангамж ашиглуулснаас авах шимтгэл, хураамжийн орлогоос бүрдэнэ.

50¹.3.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг эрхлэх этгээд болон энэ хуулийн 50¹.1-д заасан программ хангамжид тавигдах нөхцөл, шаардлагыг Хороо тогтооно.

50¹.4.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа нь энэ хуулийн 11.1-д заасан үнэт цаасыг нийтэд санал болгох ажиллагаанд хамаарахгүй бөгөөд хөрөнгө оруулалт татах этгээд болон хөрөнгө оруулагчдад тавигдах нөхцөл, шаардлагыг Хороо тогтооно.

50¹.5.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаанд тавигдах жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн татан төвлөрүүлэх хөрөнгийн нийт хэмжээ, хөрөнгө оруулалт татах хугацаа болон нэг иргэн, хуулийн этгээдийн хөрөнгө оруулах хөрөнгийн дээд хэмжээ, хязгаарлалтыг Хороо тогтооно.

50¹.6.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан журмыг Хороо тогтооно.”

3/ 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“5.4.Засгийн газраас үнэт цаас гаргах гаргах, түүний анхдагч болон хоёрдогч зах зээлийн үйл ажиллагаа нь энэ хуулийн 3.5-д заасны дагуу Өрийн удирдлагын тухай хуулиар зохицуулагдана.”

4/ 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“9.2.Аймаг, нийслэлийн Засаг даргаас нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийг Хороонд бүртгүүлэх ба уг бүртгэлийн хялбаршуулсан журмыг Хороо тогтооно.”

5/ 9 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг:

“9.18. Хороо нь тодорхой шалгуур хангасан үнэт цаасыг хялбаршуулсан журмаар бүртгэж болох ба үүнтэй холбогдсон журмыг Хороо тогтооно.”

6/20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“20.2.Аймаг, нийслэлийн Засаг даргад энэ хуулийн 20.1.3, 20.1.4, 20.1.6-20.1.8, 20.1.10 дахь заалт хамаарахгүй.”

7/ 23 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

“23.7.Энэ хуулийн 23.4-т заасан саналын эрхгүй хувьцааг эзэмшигчтэй холбогдох этгээд болон Компанийн тухай хуульд заасан нэгдмэл сонирхолтой этгээд нь тухайн саналын эрхгүй хувьцааг худалдан авахыг хориглоно.

8/ 23 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

“23.8.Энэ хуулийн 23.7-т заасан этгээдийн хууль зөрчиж худалдаж авсан хувьцаа нь саналын эрхгүй байна.”

9/ 33 дугаар зүйлийн 10 дахь хэсэг:

“33.10.Энэ хуулийн 24.1.18-д заасан зохицуулалттай үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлагыг Хороо тогтооно.”

10/ 36 дугаар зүйлийн 17 дугаар хэсэг:

“36.17.Брокерын үйл ажиллагаа эрхлэгч этгээд өөрийн харилцагчид зориулан үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг үзүүлж болох бөгөөд дээрх харилцааг зохицуулсан нарийвчилсан журмыг Хороо тогтооно.”

11/ 36 дугаар 18 дугаар хэсэг:

“36.18.Брокер номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг Хороо олгоно.”

12/ 45 дугаар зүйлийн 10 дахь хэсэг:

“45.10.Номинал эзэмшигчээс бусад харилцагчийн үнэт цаасыг тухайн харилцагчийн нэр зааж үнэт цаасны дансанд хадгална.”

13/ 45 дугаар зүйлийн 11 дэх хэсэг:

“45.11.Үнэт цаасны шилжүүлгийн болон мөнгөн төлбөрийн гүйлгээнд саатал гарсан тохиолдолд холбогдох арга хэмжээг авах, сааталтай холбоотой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох;”

14/ 46 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

“46.7.Кастодианы үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь харилцагчийн нэрийн өмнөөс, харилцагчийн зөвшөөрлөөр үнэт цаасны төлбөр, шилжүүлэг гүйцэтгэж болно.”

15/ 46 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

“46.8.Кастодианы харилцагч нь гадаад улсад кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, эсхүл адил зөвшөөрөлтэй тохиолдолд тухайн харилцагчийн дансан дахь бенефициар өмчлөгчдийг тухайн харилцагч дотоод бүртгэлээр өөрөө тодорхойлно. Тухайн улсын харилцагчийн дотоод бүртгэлтэй холбоотой аливаа асуудал тухайн улсын хууль эрхзүйн орчинд хамаарна.”

16/ 46 дугаар зүйлийн 9 дахь хэсэг:

“46.9.Энэ хуулийн 46.8.-т заасан кастодианы харилцагч нь Хороо, үйлчилгээ үзүүлж буй кастодианы эрхэлж байгаа этгээдийн шаардлагаар үнэт цаасны бенефициар өмчлөгчдийн мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.”

17/ 50 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“50.4.Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох аргачлал, үйл ажиллагааны журмыг Хороо тогтооно.”

18/ 70 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“70.4.Мэргэжлийн холбоо нь мэргэжлийн сургалт явуулах, давтан сургах бүрэн эрхтэй байна.”

19/ 80 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“80.6.Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах үйлдлээс сэргийлэх харилцааг зохицуулсан журмыг Хороо тогтооно.”

20/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 34 дэх заалт:

“4.1.34.“форвард гэрээ” гэж талууд тодорхой тоо, хэмжээ бүхий хөрөнгийг урьдчилан тохиролцсон үнээр тогтоосон хугацаанд худалдах, худалдан авах үүргийг гэрээний талуудад үүсгэх биржийн бус зах зээл дээр арилжаалагдах үүсмэл санхүүгийн хэрэгслийг;”

21/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 35 дахь заалт:

“4.1.35.“своп гэрээ” гэж талууд хоёр өөр санхүүгийн хэрэгслээс үүсэх ирээдүйд орж ирэх мөнгөн урсгал болон төлбөрийн үүргийг тогтоосон хугацаанд солилцох үүргийг гэрээний талуудад үүсгэх биржийн бус зах зээл дээр арилжаалагдах үүсмэл санхүүгийн хэрэгслийг;”

22/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 36 дахь заалт:

“4.1.36.“хаалттай хүрээнд худалдах” гэж үнэт цаасыг нийтэд санал болгохгүйгээр, энэ хуулийн 4.1.19-д заасан этгээд болон 50-аас доош тооны энэ хуулийн 4.1.19-д зааснаас бусад этгээдэд урьдчилан тохиролцон, эсхүл шууд санал болгон худалдахыг;”

23/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 37 дахь заалт:

“4.1.37.“хувьцааны хамтын санхүүжилт” гэж гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид энэ хуулийн 501.1-д заасан этгээдээр дамжуулан өөрсдийн бизнесийн төсөл, хөтөлбөрөө хөрөнгө оруулагчдад танилцуулж, хувьцаа санал болгох замаар санхүүжилт татах үйл ажиллагааг;”

24/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 38 дахь заалт:

“4.1.38.“Номинал данс” гэж нэг буюу түүнээс дээш тооны бенефициар өмчлөгчийн мөнгөн хөрөнгө болон үнэт цаасыг нэгтгэн бүртгэж, хадгалах зориулалт бүхий номинал эзэмшигчийн дансыг.”

25/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

“5.1.3.Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;”

26/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт:

“5.1.10.банкнаас брокероор дамжуулан гаргах хадгаламжийн сертификат.”

27/ 10 дугаар зүйлийн 15 дахь хэсгийн 1 дэх заалт:

“10.15.1.Аймаг нийслэлийн засаг дарга нийтэд санал болгон өрийн хэрэгсэл гаргах;”

28/ 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 18 дэх заалт:

“24.1.18.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны;”

29/ 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12 дахь заалт:

“25.1.12.Үйл ажиллагаатай холбогдох цахим сүлжээний тогтвортой, найдвартай, үр ашигтай байдлыг хангах.”

30/ 33 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:

“33.2.4.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн тухайд Хорооноос тогтоосон шаардлагыг хангасан тусгай программ хангамжтай байх;”

31/ 38 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 4 дэх заалт:

“38.5.4.Хөрөнгө оруулалтын менежментийн компани үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр зах зээлийн индекс болон бусад санхүүгийн хэрэгслээр бүрдүүлсэн багцыг нэгж эрхээр солих замаар арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан олон нийтэд чөлөөтэй арилжаалж, эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэг индексийн багцад суурилсан сан;”

32/ 63 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 19 дахь заалт:

“63.1.19.Энэ хуулийн 9.3-т заасан үнэт цаасыг Хороо бүртгэх;”

33/ 63 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 20 дахь заалт:

“63.1.20.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны журмыг тогтоож, үйлчилгээ үзүүлэгч этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасах.”

34/ 63 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 21 дахь заалт:

“63.1.21.Үнэт цаасны зах зээлд технологид суурилсан шинэлэг санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг хязгаарлагдмал хүрээнд бодит орчин,

тодорхой цаг хугацаанд турших, нэвтрүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулсан сэндрбокс зохицуулалтын журмыг батлах, сэндрбоксоос амжилттай гарсан тохиолдолд оролцогчид холбогдох тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх;”

2 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4 дэх заалтын “банкнаас” гэсний өмнө “энэ хуулийн 5.1.10-т зааснаас бусад” гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “Засгийн газар” гэсний дараа “Засгийн газрын нэгдэн орсон олон улсын санхүүгийн байгууллага” гэж, 9 дүгээр зүйлийн 9.5.2 дахь заалтын “үнэт цаасны” гэсний өмнө “энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан” гэж, 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсгийн “хүсэлтийг” гэсний дараа “арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлсэн тухай зөвшөөрөл, мэргэжлийн холбооны шийдвэр,” гэж 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийн “сунгаж болно” гэсний өмнө “нэг удаа” гэж, 9 дүгээр зүйлийн 9.14 дэх хэсгийн “хамтран хариуцна” гэсний өмнө “, андеррайтер” гэж, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “журам” гэсний өмнө “болон хуваарилах” гэж, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтын “Компанийн” гэсний дараа “бүх төрлийн үнэт цаас эзэмшигчдэд бодит өөрчлөлт бүхий нөлөө үзүүлэх” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.12 дахь заалтын “хөрөнгө оруулалтын” гэсний өмнө “хамтын” гэж, 33 дүгээр зүйлийн 33.6.2 дахь заалтын “хуулийн 33.3” гэсний дараа “болон 33.10” гэж, 36 дугаар зүйлийн 36.11 дэх хэсгийн “дансанд байршуулах” гэсний өмнө “эсвэл мөнгөн хөрөнгийн номинал” гэж, 45 дугаар зүйлийн 45.6 дахь хэсгийн “бүртгэлийн үйл ажиллагаа” гэсний өмнө “тухайлсан” гэж, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “санал болгон” гэсний өмнө “эсхүл энэхүү хуулийн 4.1.19-д заасан этгээдэд” гэж, 51 дүгээр зүйлийн 51.1.1 дэх заалтын “болон” гэсний өмнө “үнэт цаасны итгэмжлэн удирдах, хувьцааны хамтын санхүүжилтийн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт:

“4.1.1.“үнэт цаасны зах зээл” гэж үнэт цаас болон үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгүүлэх, гаргах, арилжих, түүгээр гэрчлэгдсэн эрхийг шилжүүлэх, клиринг, төлбөр тооцоо, гүйцэтгэх, хадгалах үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон биржийн болон биржийн бус зах зээлийн харилцааг;”

2/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

“4.1.2.“биржийн зах зээл” гэж арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлсэн үнэт цаас болон үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжаалах зах зээлийн харилцааг;”

3/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

“4.1.3.“биржийн бус зах зээл” гэж энэ хуулийн 4.1.19-д заасан этгээд хууль тогтоомжоор хориглоогүй, өөрийн өмчлөлийн болон өмчлөгчөөс эрх олгосон хөрөнгөөр санхүүгийн хэрэгслийг харилцан шууд худалдах, худалдан авах зэрэг үйл ажиллагаа явуулж байгаа зах зээлийн харилцааг;”

4/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дахь заалт:

“4.1.4.“үнэт цаасны анхдагч зах зээл” гэж үнэт цаас гаргагч үнэт цаасаа нийтэд санал болгон эсхүл хаалттай хүрээнд хөрөнгө оруулагчдад худалдахтай холбогдсон харилцааг;”

5/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

“4.1.7.“үүсмэл санхүүгийн хэрэгсэл /дериватив/” гэж опцион, фьючерс, своп, форвард зэрэг үнэт цаасны үнэ цэнэ нь аливаа хөрөнгө, хөрөнгийн багц эсвэл индексийн үнэ цэнээс хамааралтай санхүүгийн хэрэгслийг;”

6/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

“4.1.8.“үнэт цаас” гэж мөнгөн хөрөнгийн үнэ цэнийг гэрчлэх, эзэмшигч нь хоорондоо тохиролцож арилжаалж болдог санхүүгийн хэрэгслийг;”

7/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 18 дахь заалт:

“4.1.18.“мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа” гэж энэ хуулийн 4.1.19-д заасан этгээд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн түвшинд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагааг;”

8/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 19 дахь заалт:

“4.1.19.“мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч” гэж мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа хөрөнгө оруулалтын сан, тэтгэврийн сан, банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаа, даатгал, андеррайтер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд зэрэг хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд гэж тогтоосон бусад хувь хүн, хуулийн этгээдийг;”

9/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 21 дахь заалт:

“4.1.21.“нийтэд санал болгох” гэж Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу үнэт цаас гаргагч өөрөө, эсхүл андеррайтерын компаниар дамжуулан үнэт цаасаа 50-аас дээш тооны этгээдэд санал болгон худалдахаа олон нийтийн цахим сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдэгдэхийг;”

10/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 27 дахь заалт:

“4.1.27.“арилжаа эрхлэх байгууллагын зөвшөөрөл” гэж арилжаа эрхлэх байгууллагаас үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг өөрийн байгууллагын үнэт цаасны арилжаанд оруулахыг зөвшөөрсөн бүртгэлийг;”

11/ 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт:

“9.3.Урьд нь нийтэд санал болгон гаргасан тухайн төрлийн үнэт цаасыг хаалттай хүрээнд нэмж гаргах, эсхүл өөр төрлийн үнэт цаасыг хаалттай хүрээнд гаргахдаа тэдгээрийг хялбаршуулсан журмаар Хороонд бүртгүүлэх ба үүнтэй холбогдсон журмыг Хороо тогтооно.”

12/ 9 дүгээр зүйлийн 16 дахь хэсэг:

“9.16.Үнэт цаас гаргагч нь гаргаж байгаа үнэт цаасаа нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх болон арилжаа эрхлэх байгууллагын зөвшөөрлийг авах хүсэлтийг нэгэн зэрэг гаргаж болно.”

13/ 9 дүгээр зүйлийн 17 дахь хэсэг:

“9.17.Үнэт цаас гаргагчийн тухай үнэт цаасыг арилжаа эрхлэх байгууллага болон мэргэжлийн холбоонд бүртгэсэн нь нийтэд санал болгох, эсхүл нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэх үндэслэл болохгүй.”

14/ 10 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 9 дахь заалт:

“10.5.9.Нийтэд санал болгож байгаа үнэт цаасны тоо, хэлбэр, нэрлэсэн үнэ болон тэдгээрийг нийтэд санал болгох арилжих болон хуваарилах нөхцөл, журам, ногдол ашиг хуваарилах нөхцөл, журам, өрийн хэрэгслийн хувьд хугацаа, үндсэн төлбөр, хүү төлөх нөхцөл, журам;”

15/ 11 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг:

“11.10.Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны бүртгэлд бүртгүүлээгүй болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцааг нийтэд санал болгохыг хориглоно.”

16/ 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“12.2.Үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах зөвшөөрлийг Хороо олгох бөгөөд Хороо уг зөвшөөрлийг олгохдоо арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлсэн тухай тодорхойлолт, мэргэжлийн холбооны шийдвэр , үнэт цаас гаргагчийн хүсэлтэд үндэслэн олгоно.”

17/ 12 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“12.6.Хороо үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд худалдсан тухай тайланг ажлын гурван өдөрт багтаан хянах ба зөрчил гараагүй, үнэт цаасны анхдагч зах зээлд худалдах ажиллагаа амжилттай болсон гэж үзсэн тохиолдолд үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг олгоно. ”

18/ 12 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

“12.7.Хороо дор дурдсан нөхцөлийн аль нэг нь бүрэн хангагдсан бол үнэт цаасны анхдагч зах зээлд худалдах ажиллагааг амжилттай болсон гэж үзнэ.”

19/ 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

“12.8.Хорооноос үнэт цаасны анхдагч зах зээлд худалдах ажиллагааг амжилттай болсон тухай шийдвэр гаргаж, нийтэд мэдээлснээс хойш үнэт цаасны анхдагч зах зээлийн хэлцлийг буцаахгүй.”

20/ 12 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:

“12.9.Үнэт цаас гаргагч нь үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд худалдах ажиллагаанаас төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг тухайн үнэт цаасны танилцуулгад зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.”

21/ 16 дугаар зүйл:

“16 дугаар зүйл.Компанийн өрийн хэрэгсэл

16.1.Компани нь биржийн болон биржийн бус зах дээр нийтэд санал болгох, эсхүл хаалттай хүрээнд энэ хуульд нийцүүлэн өрийн хэрэгсэл гаргаж болно.

16.2.Компанийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийг бүртгэх журмыг Хороо тогтооно.

16.3.Компанийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгсэл нь үүргийн гүйцэтгэлийг хангах өөрийн, эсхүл гуравдагч этгээдээс тусгайлан гаргасан барьцаа, баталгаатай байж болно.

16.4.Компанийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийн үнийн дүн нь тухайн компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүү байх нөхцөлд Хорооноос тогтоосон шалгуурыг хангасан байна.

16.5.Компани нь энэ хуулийн 16.3-т заасан үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг барьцаалахгүй бол санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоолгосон байна.

16.6.Хорооноос тогтоосон шалгуурыг хангасан компани нийтэд санал болгон гаргах тодорхой үнийн дүн бүхий өрийн хэрэгслүүдийг бүхэлд нь нэг удаа бүртгүүлж, тэдгээрийг нэг удаа, эсхүл хэд хэдэн удаагийн давтамжтайгаар хэсэгчлэн санал болгон худалдаж болно.

16.7.Энэ хуулийн 10.1 дэх хэсэг нь Хороонд бүртгүүлсэн өрийн хэрэгслүүдийг хэд хэдэн удаа хэсэгчлэн гаргах замаар нийтэд санал болгон худалдахад хамаарахгүй.

16.8.Нийтэд санал болгон, эсхүл нийтэд санал болгогчгүйгээр хаалттай хүрээнд санал болгосноос үл хамааран Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуульд заасан татан буугдах нөхцөл бүрдсэн, эсхүл төлбөрийн чадваргүй болсон нөхцөлд тухайн компанийн өрийн бичгийг эзэмшигч этгээд өрийн бичгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг тэргүүн ээлжид компаниас нэхэмжлэх давуу эрхтэй.”

22/ 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“17.3.Монгол Улсад бүртгэгдсэн хуулийн этгээд гадаад улсад нийтэд санал болгон үнэт цаас гаргах, эсхүл гадаад улсын хөрөнгийн биржид бүртгүүлэх тохиолдолд Хороонд мэдэгдэнэ.”

23/ 19 дүгээр зүйл:

“19 дүгээр зүйл.Үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжих

19.1.Үүсмэл санхүүгийн хэрэгслийг биржийн зах зээл дээр арилжих ерөнхий журмыг Хороо тогтоох ба үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагчид тавих нөхцөл, шаардлага, шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих журмыг тухайн арилжаа эрхлэх байгууллагаас тогтооно.

19.2.Үүсмэл санхүүгийн хэрэгслийг биржийн бус зах зээл дээр арилжих бол хууль, олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтоосон заншлыг баримтална.

19.3.Үүсмэл санхүүгийн хэрэгсэлд опцион, фьючерс, форвард, своп хэлцэл орно.”

24/ 27 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“27.4.Үнэт цаасны арилжааны клиринг, төлбөр тооцооны, эсхүл кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүсэж байгаа хуулийн этгээд нь хөрөнгийн биржийн арилжааны цахим сүлжээнд холбогдох нөхцөлийг хангасан байх бөгөөд энэ талаарх баримтыг энэ хуулийн 27.1-д заасан өргөдөлд хавсаргана.”

25/ 27 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“27.5.Үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүсэж байгаа хуулийн этгээд нь үнэт цаасны арилжааны клирингийн, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх байгууллагын цахим сүлжээнд холбогдох нөхцөлийг хангасан байх бөгөөд энэ талаарх баримтыг энэ хуулийн 27.1-д заасан өргөдөлд хавсаргана.”

26/ 36 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

“36.8.Брокер нь харилцагчийн мөнгөн хөрөнгө, үнэт цаасыг мөнгөн хөрөнгө, үнэт цаас хадгалах эрх бүхий байгууллага эсвэл мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номинал дансанд тус тус өөрийн мөнгөн хөрөнгө, үнэт цааснаас тусад нь байршуулж ажиллана.”

27/ 36 дугаар зүйлийн 14 дэх хэсэг:

“36.14.Брокерийн нэр дээрх харилцагчийн мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номинал данснаас брокерын бусдын өмнө хүлээсэн үүргийг гүйцэтгэхгүй ба төрийн эрх бүхий байгууллагаас брокерийн дансыг битүүмжлэх тохиолдолд харилцагчийн мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номинал дансыг давхар битүүмжлэхийг хориглоно.”

28/ 36 дугаар зүйлийн 15 дахь хэсэг:

“36.15.Брокерын компанийн мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номинал данстай холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулсан журмыг Хороо тогтооно.”

29/ 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“41.1.Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд худалдах, хуваарилах, нийтэд санал болгох үнийг тогтоох, бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, үнэт цаасны худалдагдаагүй үлдсэн хэсгийг андеррайтерийн гэрээнд заасан хэмжээгээр худалдаж авахтай холбоотой харилцааг андеррайтерийн үйл ажиллагаа гэнэ.”

30/ 41 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 1 дэх заалт:

“41.4.1.үнэт цаасны танилцуулга бэлтгэх, үнэт цаас гаргагч, түүний санал болгох үнэт цаасны талаар судалгаа, шинжилгээ хийх;”

31/ 43 дугаар зүйл:

“43 дугаар зүйл.Үнэт цаасны клирингийн үйл ажиллагаа

43.1.Үнэт цаасны клирингийн үйл ажиллагаа /цаашид “клирингийн үйл ажиллагаа” гэх/ гэж клирингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд /цаашид “клирингийн төв” гэх/-ээс хэрэгжүүлэх дор дурдсан үйл ажиллагааг ойлгоно. Үүнд:

43.1.1.үнэт цаасны арилжааны хэлцлийг хуваан, худалдан авагч талын эсрэг худалдагч тал, худалдагч талын эсрэг худалдан авагч тал болох;

43.1.2.үнэт цаасны арилжааны хэлцлийн эсрэг тал болсонтой холбоотой эрх үүргийг хэрэгжүүлэх;

43.1.3. үнэт цаасны арилжааны баталгаажсан болон арилжааны бус хэлцлийн дагуу үнэт цаас шилжүүлэх болон мөнгөн төлбөр гүйцэтгэхтэй холбоотой арилжаанд оролцогч талуудын хүлээх үүргийг хэлцэл тус бүрээр эсвэл цэвэршүүлсэн дүнгээр тодорхойлох;

43.1.4.үнэт цаас шилжүүлэх болон мөнгөн төлбөр гүйцэтгэх даалгаврыг эрх бүхий төлбөр тооцооны байгууллагад илгээх;

43.1.5.үнэт цаасны арилжааны хэлцэлд оролцогч талууд үүргээ биелүүлээгүйгээс шалтгаалан үүсэх талуудын болон системийн эрсдэлийг удирдах;

43.2.Клирингийн төв нь клирингийн үйл ажиллагааг шударга, үр ашигтай, үр дүнтэй зохион байгуулах, системийн эрсдэлийг бууруулах үүрэгтэй.

43.3.Клирингийн төв гишүүнчлэлтэй /цаашид “клирингийн гишүүн” гэх/ байх бөгөөд клирингийн төвийн тусгай зөвшөөрлийн шалгуурыг Хорооны журмаар,

клирингийн төвийн гишүүн элсүүлэх шалгуурыг клирингийн төвийн журмаар тус тус зохицуулна.

43.4. Үнэт цаасны арилжааны клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагааг эрсдэлгүй найдвартай гүйцэтгэх зорилгоор клирингийн төв нь клирингийн гишүүнээс барьцаа шаардах, барьцаа хөрөнгийг удирдах, клирингийн гишүүн нь баталгаажсан хэлцэлтэй холбоотой гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцаа хөрөнгө, тухайн хэлцэлд хамаарах үнэт цаасыг үл маргах журмаар захиран зарцуулах эрхтэй.

43.5. Үнэт цаасны арилжааны клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагааг эрсдэлгүй найдвартай гүйцэтгэх зорилгоор клирингийн гишүүн нь гэрээт үнэт цаасны компани болон харилцагчаас барьцаа шаардах, барьцаа хөрөнгийг өөрийн дансанд байршуулах, баталгаажсан хэлцэлтэй холбоотой гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцаа хөрөнгийг үл маргах журмаар захиран зарцуулах эрхтэй.

43.6. Үнэт цаасны арилжааны клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагааг эрсдэлгүй найдвартай гүйцэтгэх зорилгоор үнэт цаасны компани өөрийн харилцагчаас захиалгын үнийн дүнгийн тодорхой хувиар тооцон үүргийн гүйцэтгэл хангах баталгаа буюу маржин байршуулахыг шаардах, маржинг өөрийн дансанд байршуулах, баталгаажсан хэлцэлтэй холбоотой гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд маржин хөрөнгийг үл маргах журмаар захиран зарцуулах эрхтэй.

43.7. Үнэт цаасны арилжааны клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагааны системийн эрсдэлийг удирдах зорилгоор клирингийн төв нь төлбөрийн баталгааны сан байгуулах, төлбөрийн баталгааны сангийн үйл ажиллагааны журам гаргах, удирдан зохион байгуулах үүрэгтэй. Төлбөрийн баталгааны сангийн эх үүсвэр нь клирингийн төв, клирингийн гишүүний төлбөрийн баталгааны санд оруулсан мөнгөн хуримтлалаас бүрдэнэ.

43.8. Шүүхээс арилжаа эрхлэх байгууллагын баталгаажсан хэлцлийг хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцсон эсхүл арилжаанд оролцогч этгээд төлбөрийн чадваргүй болсон, дампуурлын хэрэг үүсгэсэн, татан буугдсантай холбоотой аливаа этгээдийн эд хөрөнгийг хуваарилах, эрх хүлээн авагчийг томилох тохиолдолд тухайн баталгаажсан хэлцлийн клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагаатай холбоотой хэрэгжүүлсэн арга хэмжээ, шимтгэл, хураамжийг буцаахгүй бөгөөд гагцхүү буруутай этгээдээр үнэ болон учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

43.9. Энэ хуулийн 43.7-д заасан баталгаажсан хэлцлээс үүссэн учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

43.10. Үнэт цаасны арилжааны баталгаажсан хэлцэлтэй холбоотой төлбөрийн үүрэг бүрэн төлөгдөж дуусах хүртэлх хугацаанд тухайн хэлцлийн клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагаатай холбоотой арилжаа эрхлэх байгууллага, клирингийн төв, төлбөр гүйцэтгэх байгууллагын энэ хуульд заасны дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагааг зогсоохгүй.

43.11.Клирингийн төв нь тухайн мэдээллийг нийтэд нээлттэй болгох талаар Хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас бичгээр шаардсан, эсхүл шүүхийн шийдвэр гарснаас бусад тохиолдолд өөрийн гишүүн, түүний харилцагчийн талаарх өөрт байгаа бүх мэдээллийн нууцлалыг хадгална.

43.12.Клирингийн үйл ажиллагааны ерөнхий журмыг Хороо тогтоож болно.

43.13.Төлбөрийн чадваргүй болсон эсхүл дампуурсан клирингийн гишүүний хөрөнгийг холбогдох хуулийн дагуу хуваарилахдаа тэргүүн ээлжинд үнэт цаасны төлбөрийн үүргийг барагдуулна.”

32/ 44 дүгээр зүйл:

“44 дүгээр зүйл.Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа

44.1. Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа гэж төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн хэрэгжүүлэх дор дурдсан үйл ажиллагааг ойлгоно. Үүнд:

44.1.1.холбогдох байгууллагаас ирүүлсэн үнэт цаасны шилжүүлэг болон мөнгөн төлбөрийн үүргийг шалган баталгаажуулах;

44.1.2.үнэт цаасны шилжүүлэг болон мөнгөн төлбөрийн гүйлгээг хэлцэл тус бүрээр эсвэл цэвэршүүлсэн дүнгээр нэгэн зэрэг гүйцэтгэх;

44.1.3. үнэт цаасны шилжүүлгийн болон мөнгөн төлбөрийн гүйлгээнд саатал гарсан тохиолдолд холбогдох арга хэмжээг авах, сааталтай холбоотой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох;

44.1.4. үнэт цаасны шилжүүлгийн болон мөнгөн төлбөрийн гүйлгээний тайланг холбогдох байгууллагад хүргүүлэх;

44.2. Үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог холбогдох журамд заасан хугацаанд багтаан гүйцэтгэнэ.

44.3. Үнэт цаасны шилжүүлэг хийгдсэнээр үнэт цаасны өмчлөх эрх шилжсэнд тооцно.”

33/ 45 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

“45.7.Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь үнэт цаас хадгалуулагчийн өмчлөл дэх үнэт цаасны ногдол ашиг болон үнэт цаас худалдсаны төлбөрийг банкин дахь харилцагчийн нэр дээрх дансанд шилжүүлнэ.”

34/ 45 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:

“45.9. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь нийтэд болон хаалттай хүрээнд санал болгон гаргасан үнэт цаасыг үнэт цаасны төвлөрсөн бүртгэлийн санд бүртгэнэ.”

35/ 46 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“46.1. Үнэт цаас өмчлөгчийн өмчлөл дэх үнэт цаасыг номинал эзэмшигчийн хүрээнд хадгалах, хадгалж буй үнэт цаасыг тухайн харилцагчийн нэрийн дансанд бүртгэснээр өмчлөх эрхийг баталгаажуулах, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх бусад эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйлчилгээг үзүүлэх ажиллагааг кастодианы үйл ажиллагаа гэнэ.”

36/ 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

“49.1.4. энэ хуульд заасны дагуу арилжаа зохион байгуулах болон үнэт цаас бүртгэх тухай журам, тэдгээрт оруулсан нэмэлт өөрчлөлтийг батлах зөвшөөрлийг Хорооноос авах;”

37/ 72 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“72.2. Мэргэжлийн холбоо нь энэ хуулийн 72.1-д заасан дүрэм, журмыг бүх гишүүдийн хурлаар батлах ба уг дүрэм, журмыг Хороонд мэдэгдэнэ.”

38/ 73 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“73.1. Мэргэжлийн холбооны бүх гишүүдийн хурал байна.”

39/ 75 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“75.2. Өөрийгөө зохицуулах байгууллагын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд Хороо шалгалт хийх ба ингэхдээ мэргэжлийн холбооны шалгалтыг энэ хуулийн 70.1, 70.3-д заасан чиглэлийн хүрээнд хийнэ.”

4 дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын “зохицуулалттай” гэснийг “үнэт цаасны” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтын “дуусмагц” гэснийг “, нөхцөлийн дагуу” гэж, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “,эсхүл” гэснийг “болон” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “зохицуулалттай этгээдтэй” гэснийг “андеррайтертай” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “бүртгэл болон хөрөнгийн биржийн бүртгэлийн аль алинд нь” гэснийг “бүртгэлд” гэж, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн “арилжсан” гэснийг “худалдсан” гэж, 12 дугаар зүйлийн 12.7.1 дэх заалтын “тухайн үнэт цаасны арилжаанаас” гэснийг “татан” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “нэгэн адил” гэснийг “хадгалалтын гэрээнд заасны дагуу” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалтын “арилжааны тооцооны” гэснийг “клирингийн” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.8 дахь заалтын “арилжааны төлбөрийн” гэснийг “төлбөр тооцооны” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.18 дахь заалтын дугаарыг 24.1.19 гэж, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “24.1.18” гэснийг “24.1.19” гэж, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “24.1.17” гэснийг “24.1.18” гэж, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийн “24.1.18” гэснийг “24.1.19” гэж, 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийн “24.1.18” гэснийг “24.1.19” гэж, 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн

“24.1.1-24.1.14” гэснийг “24.1.1-24.1.6, 24.1.12-24.1.14” гэж, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “Зохицуулалттай” гэснийг “Энэ хуулийн 24.1.1-24.1.14-д заасан” гэж, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “24.1.17” гэснийг “24.1.8” гэж, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “24.1.17” гэснийг “24.1.18” гэж, 33 дугаар зүйлийн 33.3 дахт хэсгийн “24.1.17” гэснийг “24.1.18” гэж, “35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийн “байгууллагын саналыг харгалзан Хороо” гэснийг “байгууллага” гэж, 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийн “нөхцөл, гэрээ байгуулах журмыг” гэснийг “нөхцөлийг” гэж, 36 дугаар зүйлийн 36.5 дахь хэсгийн гүйцэтгэх гэснийг “арилжааны цахим сүлжээнд оруулах” гэж, 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “бусад” гэснийг “хуулийн этгээдийн эрхгүй гэрээний” гэж, 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсгийн “болон” гэснийг “хөтлөх эрхтэй ба” гэж, 47 дугаар зүйлийн 47.4.1 дэх заалтын “бүтээгдэхүүнд” гэснийг “бүтээгдэхүүн, эрдэс баялгийн болон тэдгээрт” гэж, 47 дугаар зүйлийн 47.4.2 дахь заалтын “тооцооны” гэснийг “клирингийн” гэж, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн “төлбөр, тооцооны” гэснийг “клиринг, төлбөр тооцооны” гэж, 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсгийн “тооцооны” гэснийг “клирингийн” гэж, 49 дүгээр зүйлийн 49.1.1 дэх заалтын “бүтээгдэхүүнд” гэснийг “бүтээгдэхүүн, эрдэс баялгийн болон тэдгээрт” гэж, 63 дугаар зүйлийн 63.1.6 дахь заалтын “хасах” гэснийг “хасахтай холбоотой нарийвчилсан журмыг тогтоох” гэж, 63 дугаар зүйлийн 63.1.10 дахь заалтын “хасах” гэснийг “хасахтай холбоотой нарийвчилсан журмыг тогтоох” гэж, 63 дугаар зүйлийн 63.1.19 дахь заалтын дугаарыг 63.1.22 гэж, 75 дугаар зүйлийн 75.2 дахь хэсгийн “Хороо шалгалт хийнэ.” гэснийг “Хороо шалгалт хийх бөгөөд мэргэжлийн холбооны шалгалтыг хийхэд энэ хуулийн 70.1, 70.3-д заасан чиглэлийн хүрээнд хийнэ.” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн хуулийн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “үнэт цаасны анхдагч зах зээлд санал болгох” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.13 дахь хэсгийн “9.9” гэснийг, 27 дугаар зүйлийн 27.2.3 дахь заалтын “болон эргэлтийн” гэснийг, 28 дугаар зүйлийн 28.1.4 дэх заалтын “болон эргэлтийн” гэснийг, 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн “гурван жилийн хугацаагаар” гэснийг, 41 дүгээр зүйлийн 41.4.6 дахь заалтын “өөрийн харилцагчид” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.4 болон 9.9 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.5.16 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.5 болон 12.7.3 дахь заалт, 49 дүгээр зүйлийн 49.1.3 дахь заалт, 70 дугаар зүйлийн 70.1.2 дахь заалтыг тус бүрийг хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2021 оны _ дугаар сарын _-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

